

**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН
ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.3.Олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас тогтоосон нөхцөл, шаардлагыг үндэслэн энэ хуулийн 14.1.3-т заасан зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтооно.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж

2.Төслийн 3 дугаар зүйл “зургаа хүртэлх” гэснийг “таван” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд

Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.3.Зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэлийг Монголбанкнаас заасан зарчмыг баримтлан, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд тогтооно.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг бүхэлд нь хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа

3.Төслийн 2 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.2.Зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлал бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтоох үндсэн зарчим, нөхцөл шаардлагыг Монголбанк батална. Зээлийн мэдээллийг зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтооход ашиглана.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал

4.Төслийн 3 дугаар зүйл “зургаа хүртэлх” гэснийг “гурван” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж

**ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН
ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Нэг. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.Зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлал, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтоох үндсэн зарчим, нөхцөл шаардлагыг холбогдох байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Т.Жамбаажамц/-д тус тус даалгасугай.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал

Хоёр. Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “зургаа хүртэлх” гэснийг “гурван” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж

----oOo----